



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/150

Булган сум

**Архивын сан хөмрөгийн баримтад тооллого хийх,
тоо бүртгэлийн баримт бичигт иж бүрэн нягтлан шалгалт
зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/23 дугаар тушаал, Архивын ерөнхий газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/56 дугаар тушаал, Архивын ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/129 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архивын ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор архивын сан хөмрөгийн баримтад тооллого хийх, тоо бүртгэлийн баримт бичигт иж бүрэн нягтлан шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Д.Батсайхан (Архивын тасгийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд: Ш.Болдбаатар (Төрийн архивын Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч)

Д.Хажидмаа (Төрийн архивын Сан хөмрөгч)

Ж.Эрдэнэтуяа (Төрийн архивын Архивч, сэлбэн засагч)

Л.Буянжаргал (Төрийн архивын Цахимжуулалт

хариуцсан ажилтан)

Х.Ундармаа (Төрийн архивын Цахимжуулалт хариуцсан ажилтан)


Хөмрөг үүсгэгч байгууллагуудын Архив, бичиг хэргийн эрхлэгч

Нарийн бичгийн дарга: Э.Болорзул (Төрийн архивын Зааварлагч, арга зүйч)

2. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд ажлын төлөвлөгөө, хуваарийг гарган батлуулж, ажлыг хугацаанд нь чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг ажлын хэсэг (Д.Батсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6334010200